



MONGOLIA
MINISTRY OF FOREIGN AFFAIRS
AND TRADE

К/Н-1826

Монгол Улсын Гадаад харилцааны яам Бүгд Найрамдах Индонез Улсын Гадаад хэргийн яаманд яаманд хүндэтгэлээ илэрхийлэх ялдамд танай 2011 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн № D/02902/09/2011/30 ноотны хариу болгож Дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд харилцан визгүй зорчих тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Индонез Улсын Засгийн газар хооронд 2002 оны 10 дугаар сарын 7-нд байгуулсан хэлэлцээрийн I, VI, VII зүйлд дараахь шинэчлэл болон албан ёсны нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг зөвшөөрч байгааг мэдэгдэх завшаан тохиолдов. Үүнд:

Нэгдүгээр зүйл

Визээс чөлөөлөх

Хоёр талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд нөгөө талын нутаг дэвсгэрт 30-аас илүүгүй хоног зорчих, дамжин өнгөрч болно.

Зургадугаар зүйл

Паспортын загварууд

- 1) Талууд паспортын загваруудыг дипломат шугамаар солилцоно.
- 2) Талууд дипломат болон албан паспортыг шинэчилсэн эсхүл хүчин төгөлдөр үйлчилж буй дипломат болон албан паспортад өөрчлөлт оруулсан бол энэ тухайгаа эдгээрийг албан ёсоор хэрэглэж эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө албан бичгээр дипломат шугамаар мэдэгдэж тэдгээрийн загварыг ирүүлнэ.

БҮГД НАЙРАМДАХ ИНДОНЕЗ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН ЯАМАНД
Жакарта хот

- 3) Хэрвээ аль нэг Талын дипломат болон албан паспорттой иргэн нөгөө талын нутаг дэвсгэрт бичиг баримтаа гээж үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд тухайн иргэн өөрийн орны дипломат болон консулын төлөөлөгчийн газраар дамжуулан нэн даруй хүлээн авагч Талын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. Холбогдох дипломат болон консулын газар өөрийн орны хууль тогтоомжийн дагуу бичиг баримтаа үрэгдүүлсэн иргэнд нутаг буцах бичиг баримт бичиж өгнө.

Долоодугаар зүйл

Хүчин төгөлдөр болох, хүчинтэй хугацаа, маргаан, санал зөрөлдөөнийг зохицуулах, нэмэмэлт өөрчлөлт оруулах

- 1) Энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох дотоодын шаардлагаа биелүүлсэн тухайгаа нөгөө Талдаа мэдээлсэн нэг Талын сүүлчийн мэдээлэл өгсөн өдрөөс эхлэн энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.
- 2) Энэхүү Хэлэлцээрийг 5 /таван/ жилийн хугацаагаар байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь Хэлэлцээрийг цуцлах тухай хүсэлтээ уг хугацаа дуусахаас 90 /ер/ хоногийн өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө талдаа дипломат шугамаар мэдэгдээгүй тохиолдолд нөгөө Талдаа дипломат шугамаар мэдэгдээгүй тохиолдолд Хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаа аяндаа сунгагдах болно.
- 3) Хэлэлцээрийг хэрэгжүүлэх болон тайлбарлах явцад гарсан аливаа маргаан, санал зөрөлдөөнийг Талууд дипломат шугамаар хэлэлцэж, зөвлөлдөж шийдвэрлэнэ.
- 4) Энэхүү Хэлэлцээрт дипломат шугамаар ноот бичиг солилцох замаар харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Ийм нэмэлт, өөрчлөлтийн хүчин төгөлдөр болох хугацааг Талууд харилцан тохиролцоно.

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Гадаад харилцааны яамны 2011 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн № К/11-1826 тоот ноот, Бүгд Найрамдах Индонез Улсын Засгийн газрыг төлөөлж Бүгд Найрамдах Индонез Улсын Гадаад хэргийн яамны 2011 оны 9 дүгээр сарын 12 ны өдрийн № D/02902/09/2011/30 ноот нь Дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд харилцан визгүй зорчих тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Индонез Улсын Засгийн газар хооронд 2002 оны 10 дугаар сарын 7-нд байгуулсан хэлэлцээрийн I, VI, VII зүйлд оруулах дээрх шинэчлэл болон албан ёсны нэмэлт өөрчлөлтийг баталгаажуулж буй албан ёсны баримт бичиг болох бөгөөд 2011 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Энэхүү завшааныг ашиглан Монгол Улсын Гадаад харилцааны яам Бүгд Найрамдах Индонез Улсын Гадаад хэргийн яаманд яаманд нэн өндөр хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

Улаанбаатар хот
2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр



ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХЯМБАР

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ